

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал:

1.1. Дараахь зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх,

а/Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн

Аймгийн ЗДТГазар эрхэм зорилго, стратегийн зорилт чиглэлээ тодорхойлсон баримт бичгийг удирдлагын академитай хамтран боловсруулж хэрэгжүүлж эхэлсний дээр нийт сум, агентлаг албад, албан байгууллагын эрхэм зорилго, зорилтыг гаргуулж аймгийн ВЭБ хуудсанд байрлуулан улмаар тус тусын байгууллагын вистбюльд ил тодоор байрлуулан иргэд олон нийтэд нээлттэй сурталчилж түүнийгээ хэрэгжүүлэх арга хэмжээг жил жилийн төлөвлөгөө, хөтөлбөртөө тусган биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг жил жилдээ тодорхойлж түүнийг нийтэд сурталчлан хэрэгжүүлэх ажлыг жил улирлын төлөвлөгөөнд тодорхой тусгаж, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт үр дүнг сар, улирал, жилээр гарган тайлагнаж телевиз, сонин хэвлэлээр сурталчилж байна.

Ийнхүү сурталчлахын зэрэгцээ албан газар, байгууллагын дарга, эрхлэгч нарт 7-хоног бүр, аймгийн төвийн иргэдэд улиралд, хөдөөгийн сумын хөдөлмөрчдөд хагас жил тутам аймгийн төр захиргааны байгууллагаас зохиож буй ажил гарсан үр дүн, оршиж буй дутагдал, цаашид авах арга хэмжээгээ дэлгэрэнгүй танилцуулан тайлагнаж санал бодлыг нь сонсч ажилдаа тусган хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ 2009 онд аймгийн болон Эрдэнэцагаан, Дарьганга, Асгат сумд стартегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлээ хэрэгжүүлэх үүднээс эдийн засгийг 2009-2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Цаашид бүх сумдыг мастер төлөвлөгөөтэй болгох бэлтгэл ажил хийгдэж байна.

Биелэлт -100%

б/Албан хаагчийн ёс зүйн дүрэм :

Засгийн газрын 1999 оны 58-р тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээний тухай дүрмийн хэрэгжилтийн явц байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Ёс зүйн дүрмийг мэдээллийн самбарт ил тодоор байршуулсанаар олон нийтийн зүгээс уул дүрмийн биелэлтийг хянах боломжийг олгосон юм. 2009 оны хувьд орон нутагт албан хаагчдаас ёс зүйн дүрмийг зөрчиж хариуцлага тооцуулсан төрийн захиргааны ажилтан 12 байгаа нь өмнөх дөрвөн жилийн дунджаас 3-аар буюу 30 хувиар доогуур байна.

Биелэлт -100%

в/Төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь

Аймгийн Тамгын газарт олон нийттэй харилцах , иргэдийн өргөдөл гомдлын асуудал хариуцсан мэргэжилтнийг орон тоогоор, сумдын ЗДТГ, агентлаг, албад, албан байгууллагад

дээрх ажилтныг орон тооны бусаар ажиллуулж байгаа нь байгууллага, иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг нэг дор хүлээн авч шийдвэрлэх, хариуг хугацаанд өгөх ажил цэгцлэгдсэн юм. Түүнчлэн иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол хүлээж авах, түүнийг шийдвэрлэх журмыг тусгайлан боловсруулж батлан мөрдүүлж байна. Тухайн ажлыг хариуцсан мэргэжилтний өрөөний дугаар, нэр хаяг, харилцах утасыг нийтэд ил байрлуулан тавьсан нь иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтантай уулзаж харьцах, санал бодлоо илэрхийлэх, гаргасан өргөдөл, гомдолд хариу авах ажлыг шуурхай, чирэгдэлгүй болгоход ач тусаа өгч олны талархал хүлээж байна.

Иргэдийг хүлээж авч уулзах цагийн хуваарь, өрөөг тусгайлан гарган, иргэдэд мэдээлэн мөрдөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга 7 хоног бүрийн 5 дахь өдрийн 16 цагаас Засаг даргын орлогч, тамгын газрын дарга 7 хоног бүрийн Лхагва, Пүрэв гаригийн 15 цагаас, хэлтэс, агентлагийн дарга нар иргэдийг ирсэн тухай бүрт нь хүлээн авч уулзаж ярилцан, сонсож байхаар зохицуулсан болно.

Биелэлт -100%

г/Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт

Төрийн үйлчилгээ авахтай холбогдуулан иргэдээс бүрдүүлэх материалын жагсаалтыг сум, агентлаг албад бүр, мэдээллийн самбартаа байршуулан мэдээлэх, гарын авлага болгох ажил хэвшил болоод байна. Тухайлбал: Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг авахад, Их дээд сургуульд төрийн тэтгэлэг, зээлээр суралцахад, Газар өмчилж авахад, Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх материалын жагсаалт зэрэг төрийн үйлчилгээ авахтай холбоотой бүх материалыг байгууллагын мэдээллийн самбарт тогтмол тавьж сурталчилж байгаагийн дээр шаардлагатай гэж үзвэл гарын авлага болгон иргэд байгууллагад хүргүүлэх, үйлчлүүлэхээр ирэгсэдэд угтан үйлчлэх аргыг нэвтүүлж байгаа нь иргэдийн сэтгэлд нийцсэн ажил болж байна.

Биелэлт -100%

д/Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар

Сумдын ЗДТГ болон агентлаг албад, төсөвт байгууллагын дарга эрхлэгч нарт тогтоолын дагуу тодорхой үүрэг чиглэлийг өгч ажилласанаар байгууллага бүр дүрмээ шинэчлэн боловсруулан мөрдөж байна. Мөн бүх сумдын ЗДТГ-ыг хуулийн лавлагааны булан, танхимтай болгож холбогдох хууль тогтоомжийг Хууль зүйн хэлтэс сар улирлаар сум, агентлаг албадад хүргүүлэн, мэдээллийн самбарт тогтмол байршуулж мэдээлэх, эрх зүйн зөвлөгөө өгүүлэх, хууль тогтоомжинд орсон өөрчлөлтөөр кодификаци хийж сангаа баяжуулах арга хэмжээг тогтмол авч байна.

Шинээр гарсан болон шаардлагатай хууль тогтоомжоор аймгийн ЗДТГ-ын ажилтнууд, удирдах албан тушаалтан, хуулийн мэргэжилтнээр сурталчилгаа хийлгэх хуваарь гарган албан байгууллага, сумдад явж мэдээлэл хийдэг ажил тогтмолжлоо.

Биелэлт -100%

1.2.Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх

2009 онд нээлттэй хаалганы өдрийг төрийн байгууллагууд тусгай хуваарийн дагуу сар бүр ээлж дараатай зохион явуулж иргэдэд үйлчиллээ. Үүнээс гадна аймгийн Засаг даргын үйл ажиллагааны талаарх мэдээллийг аймгийн вэб сайтад тогтмол тавьж, иргэдийн санал

хүсэлтийг авч ирсний дээр, улирал бүр хэлтэс тасгууд үйл ажиллагааны тайлангаа орон нутгийн “Талын долгион”, “BBS”-телевизүүдээр тогтмол мэдээлж ажиллав. Энэ онд төрийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх зорилгоор нэг цонхны үйлчилгээг Баруун-Урт суманд нээж Нийгмийн даатгал, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, Иргэний бүртгэл мэдээлэл, банк, наториат зэрэг 8-төрлийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх болсон нь цаг, хүч, хөрөнгө хэмнэсэн чухал арга хэмжээ боллоо.

Биелэлт -100 %

1.3.Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх

Иргэдэд төрийн үйлчилгээтэй холбоотой аливаа мэдээллийг шуурхай, хүндрэл чирэгдэлгүй хүргэж байхын тулд хэлтэс, албадуудын албан өрөөний болон гар утсыг байнгын ажиллагаатай нээлттэй байлгах, ажлын цагаар уулзаж мэдээлэл авахыг хүссэн иргэдийг хүлээлгэхгүйгээр хүлээн авч уулзаж, хүссэн мэдээллийг нь өгч байх арга хэмжээ авч хэрэгжүүлээд байна. Мөн ЗДТГ-т эрх зүйн туслалцааны төвийг ажиллуулж иргэдэд хуулийн зөвлөгөө, хууль тогтоомжийн хүрээнд гэрээ, өргөдөл, нэхэмжлэл бичиж өгөх зэрэг үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэж, аймгийн вэб сайтаар төрийн үйлчилгээтэй холбоотой бүх төрлийн мэдээллийг тухай бүр нь мэдээлж байна.

Аймгийн Засаг дарга хагас жилд, хэлтсийн дарга нар улирал тутам телевизийн шууд ярилцлагаар орж иргэдэд мэдээлэл өгөх, ярилцлага хийж сонирхсон асуултанд хариулж, аймгийн вэб сайт, орон нутгийн “Шинэ Сүхбаатар”, “Сайхан мэдээ”, сонин, “BBS”, “Талын долгион” телевизээр тогтмол мэдээлэл хийж бодлого, шийдвэр, ажлын явц байдлаа мэдээлж байна.

Биелэлт -100 %

1.4.Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн ямаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх

Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс нь аймаг сумын Засаг даргын захирамжууд хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих хүрээнд сумын Засаг даргын захирамж 1158, Тамгын газрын даргын тушаал 416, ИТХ-ын тогтоол 67, байгууллагын даргын тушаал 11-ыг тус тус хянаж, хууль зөрчсөн 8-захирамжийг хүчингүй болгож, зөрчлийг арилгуулах, дахин давтан гагуулахгүй байх, эрх зүйн актын боловсруулалт, стандартын мөрдөлтийн талаар 25 зөвлөмж бичиж холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ. Энэ талаар байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр мэдээлж ажилласан. 2009 онд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт гараагүй болно.

Биелэлт -100 %

1.5.Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн , иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх

Аймгийн Засаг даргын захирамж, бодлогын чанартай гарч буй шийдвэрийг боловсруулахдаа Засаг даргын тамгын газрын дарга, хэлтсийн дарга нар, шаардлагатай байгууллага, мэргэжилтэн, холбогдох хүмүүсийн санал хүсэлт, иргэний нийгмийн байгууллагын саналыг авч өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу боловсруулж байна. Энэ 2009 онд Хууль зүйн хэлтэс аймгийн Засаг даргын 477 захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянаж виз олгосон нь нийт гарсан захирамжийн 92.4 хувь болж байна. Дээрх зорилтыг хангах үүднээс аймгийн Засаг даргын зөвлөлд “Иргэний нийгмийн сүлжээ”-ТББ-ын

тэргүүнийг оролцуулж аймгийн Засаг даргын аливаа шийдвэрт иргэний нийгмийн байгууллагын санал, санаачлага тусгагдах боломж бүрдээд байна.

Бодлогын баримт бичиг болон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч ажиллаж байна. Тухайлбал: “Сүхбаатар аймгийн хөгжлийн хөтөлбөр (2007-2015 он) –ийг ШУАкадеми, нутгийн зөвлөл, нутгийн эрдэмтэдийн оролцоотойгоор, “Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2004 онд НҮБХХөтөлбөр, Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл, Бүс нутгийн хөгжлийн судалгаа, сургалтын төвтэй хамтарч, “Сүхбаатар аймгийн цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр”-ийг байгаль орчны яам, нээлттэй нийгэм форум, Экологийн хүрээлэн, ШУА-тай хамтарч 2008 онд, Тамгын газрын стратегийг Удирдлагын академитай хамтарч 2006 онд боловсруулан мөрдөж байгаагийн дээр Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийг бүх сум, агентлаг, албад, иргэдийн санал дүгнэлтийг авсны үндсэн дээр боловсруулж ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж ажиллаж байна.

Биелэлт -100 %

1.6.Санал хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг, /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх

Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг амаар болон бичгээр мөн хайрцагаар, цахим сүлжээгээр авч шууд шийдвэрлэх боломжтой асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэж хариуг өгөх, холбогдох арга хэмжээг авч мэдэгдэх зэргээр ажиллалаа. Мөн аймгийн ЗДТГ иргэдийн санал, хүсэлт, өргөдлийг хүлээн авах тусгай утас (21078 дугаарыг) ажиллуулж байна. Иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг тоймлон “Шинэ Сүхбаатар” сонинд нийтлүүлж, санал хүсэлт, өргөдөл, гомдлыг тусгай дэвтэрт бүртгэж аймгийн Засаг дарга холбогдох хүмүүст танилцуулан хариуцуулан шийдвэрлэх хэлтэс тасаг, агентлаг, албадын дарга нарт уламжлан барагдуулах арга хэмжээг авч хариуг албан бичгээр эргэн мэдээлж байна. Тайлант онд өргөдөл гомдлыг улирал тутамд ЗГХЭГ-т мэдээлж, нийтэд сурталчилж ажиллаа.

Биелэлт -100 %

1.7.Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх

“ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий сайдын 2007 оны 08 тоот албан даалгаврын дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Юуны өмнө иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг захидал бүртгэх программаар тамгын газрын бичиг хэргийн ажилтан бүртгэж, олон нийттэй харилцах бодлогын мэргэжилтэн тусгайлан хяналтанд авч өргөдөлд дурьдсан асуудлыг судалж аймаг, сумдын Засаг дарга, албан байгууллагын дарга эрхлэгч нарт өргөдлийг танилцуулж дагалт цохолтыг хийлгэсний үндсэн дээр өргөдөлд дурдсан хүсэлтийг холбогдох хэлтэс, албан байгууллага, албан тушаалтантай хамтран барагдуулж, шийдвэрлэх арга хэмжээг авч байна.

2009 онд аймгийн Засаг дарга, тамгын газрын нэр дээр болон сумдын Засаг даргын Тамгын газарт иргэд, байгууллагаас амаар болон бичгээр, электрон шуудангаар нийтдээ 4836 өргөдөл гомдол ирснийг судалж үзэхэд орон сууц, гэр, мөнгөн тусламж, дэмжлэг, оюутны сургалтын төлбөр, ажлын байр болон цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, газар өмчлөн авахтай холбогдсон маргаанаа шийдвэрлүүлж өгөхийг хүссэн өргөдөл, гомдол 80.5 хувийг эзэлж байна. Өнгөрсөн онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын 99.8 хувь нь болох 4827 өргөдлийг хугацаанд нь барагдуулж хариуг өгсөн бөгөөд 9 өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлж барагдуулан хариу мэдэгдсэн нь нэг талаар хөрөнгө мөнгөтэй, нөгөө талаар зайлшгүй нягтлан шалгах шаардлагатай байсантай холбоотой байлаа. Харин шийдвэрлэгдээгүй өргөдөл байхгүй байна.

Биелэлт -99.8 %

Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал:

2.1. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх

Аймгийн ЗДТГ хүний нөөцийн стратегийг боловсруулахдаа Монгол Улсын үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, УИХ, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн холбогдох тогтоол, шийдвэр, журам заавруудыг удирдлага болгон ажилласан бөгөөд юуны урьд төрийн албанд ажиллагсадыг сонгон шалгаруулах шалгалтыг явуулахын тулд ажлын байрны тодорхойлолтыг тухайн албан байгууллагад байх шаардлагатай ажлын байр бүрээр гаргаж, тавигдах шаардлагыг нарийвчлан төлөвлөж, уул шаардлагын дагуу сонгон шалгаруулалтыг төрийн албанд анх орох иргэн, удирдах ажилтан гэсэн хоёр ангилалаар нийтэд ил тод зарлаж шалгаруулалтыг төрийн албаны зөвлөлтэй жил бүр хамтран зохион байгуулж ирлээ.

Ийнхүү сонгон шалгаруулалтаар авч ажиллуулж буй хүмүүсээ сургах, давтан сургаж мэргэшүүлэх ажлыг ТГ-ын дэргэдэх сургалтын танхимаар, бүсийн сургалтаар төвийн яам, агентлагийн чиглэлээр, удирдлагын академиар, гадаадад гэсэн хэлбэрүүдийг ашиглан зохион байгуулж байна. 2009 онд орон нутгийн сургалтын танхимаар 384, бүсийн сургалтаар 76, яам агентлагийн чиглэлээр 84, Удирдлагын академиар 4, гадаадад 12 нийт 560 ажилтан, албан хаагчдыг сургасан нь аймгийн хэмжээнд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын 27 хувь болж байна. Дээр дурьдсан сургалтыг зохион байгуулахдаа ЗГ-ын ХЭГ, БСШУЯ, ЭМЯ, НХХЯ, НДЕГ, УТЕГ, БОАЖЯ, ХХААХҮЯ, Удирдлагын академи, Хэнтий, Дорнод аймгууд дахь бүсийн сургалтын төвүүдтэй хамтран ажиллаж ирлээ. Сонгон шалгаруулалтанд тэнцэж төрийн жинхэнэ албанд ажиллах болзол журмыг хангасан иргэд болон төрийн албанд ажиллаж байгаа ажилтнуудыг удирдах болоод гүйцэтгэх албан тушаалд томилж ажиллуулахдаа тэдний мэдлэг чадвар, боловсрол, мэргэжлийн түвшин, тухайн албыг хашихад хэрхэн бэлтгэгдсэн байдал зэргийг харгалзан томилгоожуулж байгаа нь илүү ач холбогдолтой болж байна. Нөгөө талаар төрийн албанд томилогдогсдын манлайлах ур чадвар ялангуяа хүнтэй ажиллах арга барил эзэмшсэн, ажил зохион байгуулах ур чадвар, ярилцаж санаа бодлоо ойлголцох соёл зэрэг төрийн албан хаагчид байвал зохих ёс зүйн хэм хэмжээг ч харгалзан үздэг болно.

Төрийн албанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, түүнийг ашиглах чадварыг сайжруулахын тулд ажиллагсадын үр дүнгийн гэрээнд нь дээрх чиглэлээр тодорхой асуудал тусгаж үнэлж дүгнэдэг болсноор тус байгууллагын нийт ажилтнууд хэрэглээний программууд дээр бүрэн ажилладагийн дээр интернэт, дотоод сүлжээг ашиглан өөрийн хэрэгцээт мэдээллийг авах бусадтай харьцах ажил ч нэгэн адил шийдвэрлэгдээд байна.

Төрийн албан хаагчдыг төрийн захиргаа, улс төр, төрийн тусгай, төрийн үйлчилгээ гэсэн, 4-ангилалаар авч үзэж тус бүрд нь харъяалагдаж буй ажилтан нэг бүрт хувийн хэрэг нээж, дэлгэрэнгүй судалгааг төрөлжүүлэн гаргаж тусгай сантай болголоо.

Энэхүү сан нь төрийн албан хаагчдын талаархи мэдээллийг бүрэн авах боломжтойн дээр, аймгийн нийт хүн амын цахим сан байгуулж жил бүр баяжилт хийж ашиглаж байна.

Төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар холбогдох хууль тогтоомж Засгийн газрын шийдвэрийг мөрдөн ажиллахын зэрэгцээ тусгай хөтөлбөр гаргаж, байгууллага бүр дотоод журмаараа зохицуулж байна.

Төрийн байгууллагууд албан хаагчдынхаа ажлын үр дүнг улирал жилийн эцсээр дүгнэхдээ байгуулсан үр дүнгийн болон, бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний дагуу зохицуулж байна.

Үйл ажиллагаа, мэргэжлийн түвшингийн үнэлгээгээр тогтвортой өндөр үнэлгээ үзүүлж буй ажилтнуудын цалин, хөлсийг нэмэгдүүлэх хугацаанаас нь өмнө зэрэг дэв олгох, ахиулах, мөнгөн болон эд материалын урамшууллаар урамшуулах, төр, засгийн шагналд тодорхойлох зэргээр урамшууллын бүхий л хэлбэрийг ашиглаж хөхүүлэн дэмжиж байгаагийн дээр ажлын доголдол гаргасан, хариуцлагагүй хандсан ажилтнуудад хуульд

заасан сахилгын шийтгэл ногдуулж байгаа нь ажлын эцсийн үр дүн, хариуцлага сайжрах, сахилга зохион байгуулалт бэхжихэд нөлөөлж байна.

Өнгөрсөн 2009 онд төрийн албан хаагчдаас төр засгийн шагналаар 9, аймгийн шагналаар 128, байгууллага газрын шагналаар 26 хүн шагнагдаж сахилгын шийтгэл хүлээсэн ажилтан 12 байгаа нь өмнөх жилийн дунджаас 30 хувиар буурсан байна.

Аймаг сумдын төр, захиргааны байгууллага удирдлагынхаа шийдвэрийн ил тод байдлыг хангахын тулд Монгол Улсын Авилгатай тэмцэх газар, Иргэний нийгмийн зөвлөл, аймгийн Засаг дарга нарын хооронд болон аймгийн Засаг дарга, Иргэний нийгмийн байгууллагын сүлжээний зохицуулагч, ҮЭХолбоо, Ажил олгогч эздийн холбоотой гурван талт гэрээ байгуулж, тусгай төлөвлөгөөтэй ажиллаж биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна. Түүнчлэн төрийн үйлчилгээний ил тод шуурхай байдлын талаар иргэдийн дунд санал асуулга явуулж гарсан үр дүнд дурьдагдсан дутагдлыг арилгах, түүний мөрөөр дахин нягтлах арга хэмжээ авч байна. Иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж, аливаа тендер зарлаж дүгнэх, төсөл хөтөлбөр шалгаруулах, зээл олгох ажлыг эрхлэх комисс, зөвлөлийн бүрэлдэхүүнд болон, сум, агентлаг, албадын ажилд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд иргэний нийгмийн төлөөллийг оролцуулдаг болсны дээр дээрх арга хэмжээнүүдэд аудитын байгууллагыг төлөөллийн хяналт тавих, зөвлөх, үүрэгтэйгээр оролцуулдаг боллоо. Энэ нь аймгийн төр захиргааны байгууллагаас гаргаж буй шийдвэрийн үндэслэл хангагдах, аливаа ажил үйлчилгээнд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, шийдвэрлэж буй асуудлын ил тод байдлыг хангахад ач холбогдол өгч байна.

Биелэлт -100 %

2.2.Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх

Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах талаар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийг 2015 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрт тусган ажиллаж байна. Төрийн албаны удирдах ажилтны нөөц бүрдүүлэх үүднээс тэдэнд тавигдах шалгуур үзүүлэлтийг гаргаж ажлын байрны тодорхойлолтонд тусган хэрэгжүүлж байгаагийн дээр сул ажлын байранд холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалт явуулах ажлыг улсын хэмжээнд зарлах, шалгалтыг ил тод явуулах зөв байршуулах талаар стратегидаа тусгаж уул стратегийг нийтэд ил тодоор сурталчилж байна. Нөгөө талаар удирдлагаас явуулж буй аливаа үйл ажиллагааг ил тод байлгах үүднээс удирдлагын бүрэлдэхүүн, комисс, зөвлөл, хяналт шалгалтын ажилд иргэний нийгэм төрийн байгууллагын төлөөллийг оролцуулж, зарим талаар санал асуулга, судалгаа авч дүгнэлт хийх, зөвлөгөө, авах зэрэг хэлбэрүүдийг ашиглаж байна.

Байгууллагын хүний нөөц, боловсон хүчний тогтолцоог жигд байлгах үүднээс төрийн албаны мэргэшлийн шалгалтанд орж тэнцэн тангараг өргөсөн албан хаагчдаар байгууллагын дотоод нөөцийг бүрдүүлж байна.

Биелэлт -100 %

2.3.Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх

Аймгийн төрийн бүх байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нэгдсэн мэдээллийн сан бий болгон түүний үндсэн дээр хүний нөөцийн стратегийг хэрэгжүүлэх бодлогоо тодорхойлон төрийн албаны мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр боловсруулж төрийн албан хаагчдыг сурган бэлтгэх, давтан бэлтгэж мэргэшүүлэх арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. Мөн Төрийн албаны стандартын дагуу аймгийн хэмжээнд боловсон хүчний ажлыг үнэлж дүгнэхдээ тэдний оролцоог хангаж харилцан зөвшилцөх замаар дүгнэж

байгаа нь нэг талаар ил тод байдлыг хангах нөгөө талаар хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэхэд чухал алхам болж байна. Түүнчлэн хүний нөөцийн стратегийг үнэлэхэд албан хаагчид өөрсдөө оролцож байгаа нь түүний шинэчлэлд албан тушаалтнуудын зүгээс оролцох боломжийг хангаж буйн дээр боловсон хүчинтэй ажиллах, сургах, дадлагажихад бодитой нөлөө үзүүлж байна.

Биелэлт -100 %

2.4.Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх,

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлын талаар судалгаа явуулсанаар нийт ажиллагсадын 90-гаруй хувь хамрагдан байгууллага иргэдийн дунд ил тод, нээлттэй ажиллах нь үйл ажиллагааны эцсийн үр дүнд эерэг нөлөө үзүүлж байна гэсэн санал гарсан ба энэхүү санал санаачлагыг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын удирдлагын шийдвэр, төсвийн зарцуулалт, төлөвлөсөн ажил, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тухай бүр ажилчдын мэдээллийн цагаар мэдээлэх, телевиз, радио бусад мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг захидал бүртгэх программаар бүртгэн барагдуулж, хуулийн хугацаанд эргэж мэдээлэх арга хэмжээг авч байна. Ил тод байдлыг хангах үүднээс улирал, хагас жилээр байгууллагууд тусгай хуваариар орон нутгийн телевиз, мэдээллийн хэрэгслээр өөрсдийн хийсэн ажил, хийх ажлынхаа чиглэлийг ил тод мэдээлж байгууллага иргэдтэй хамтран ажиллах, тэдний дэмжлэг туслалцааг авах зэргээр төлөвлөсөн ажлаа цаг хугацаанд нь хэрэгжүүлж ирлээ.

Биелэлт -100 %

2.5.Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх

Төрийн албаны мэргэшлийн шалгалт авах зар, сул ажлын байрны захиалгыг иргэд хөдөлмөрчдөд ил тод нээлттэй байлгах үүднээс Зууны мэдээ сониноор орон даяар зарлуулан, орон нутгийн 2-телевиз, аймгийн WEB хуудсанд байрлуулж олон нийтийн сонорт хүргэсний дараа сонгон шалгаруулалтыг явуулж байна.

Биелэлт -100 %

2.6.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх

Ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн гэрээний биелэлт зэргийг дүгнэхдээ тухайн ажилтны ажлын явц байдал ямар байсныг харгалзахын дээр захиалгат бүтээгдэхүүний биелэлт, идэвх санаачилга, ажлын эцсийн үр дүнг голлон анхаарч үздэг.

Энэ талаар байгууллагын дотоод журам, ажил дүгнэх үзүүлэлтэнд тусган хэрэгжүүлж байна. Ажилтнуудын гэрээний хэрэгжилтийн үр дүнгээр урамшуулах, хариуцлага хүлээлгэх, давтан сургах, ажил өөрчлөх зэрэг арга хэлбэрийн аль тохирохыг хэрэглэж байгаа нь үр дүнгээ өгч байна.

Биелэлт -100 %

Гурав.Төсөв, санхүүгийн ил тод байдал:

3.1.Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх

Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго тэргүүлэх чиглэлтэй уялдуулахын зэрэгцээ Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Сүхбаатар аймгийн Хөгжлийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан үндсэн зорилтуудын үзэл санааг тусгаж байгаа нь орон нутгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, төсвийн үүрэг роль, түүний төлөвлөлтийг бодитой болгоход чухал нөлөө үзүүлж байна.

Биелэлт -100%

3.2.Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байх

Улс орон нутгийн батлагдсан төсөв, төсвийн нэмэлт өөрчлөлтийг Сангийн яамны болон /www.gov.mn /www.iltod.gov.mn/ цахим хуудсаас авч ажилдаа хэрэглэж байна. Мөн нээлттэй хаалганы өдөр, хурал зөвлөгөөн олон нийтийн арга хэмжээнүүдэд төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллалаа. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг иргэд олон түмэнд нээлттэй ил тод байлгах үүднээс Иргэний нийгмийн сүлжээ Төрийн бус байгууллага, түүний төлөөллийг төсөв зохиох, батлагдсан төсвийг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах явцад байнга оролцуулдаг боллоо.

Биелэлт -100%

3.3.Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх

Орон нутгийн төсөвт байгууллагуудын хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг мэдээллийн самбарт тавин нийтэд ил тод мэдээлж байгаагийн зэрэгцээ, иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулга, мэдээ мэдээллийг нээлттэй өгч ашиглуулж байна. 2009 оны эхний улирал, хагас жилийн төсвийн гүйцэтгэл, орон нутгийн татварын орлогын бүрдүүлэлт, төлөвлөгөөний биелэлтийн талаар орон нутгийн телевизүүдэд 2 удаа ярилцлага өгч, 2008 оны жилийн эцсийн ажлын дүнгийн талаар бүх суманд сурталчилгаа хийгээд байна.

Биелэлт -100%

3.4.Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх

2008 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг нийтэд болон удирдлага, бусад сонирхсон иргэд байгууллагуудад нээлттэй хүргэж, орон нутгийн мэдээллийн хэрэгсэлээр танилцуулж мэдээллийн самбараар олон нийтэд сурталчиллаа.

Биелэлт -100%

3.5.Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх

2009 оны орон нутгийн төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлтийг Сангийн яам бусад байгууллагуудад албан бичгээр хүргүүлж, мэдээллийн самбарт тавьсны дээр иргэд байгууллагуудад танилцуулж байнгын нээлттэй байлгаж байна. Мөн орон нутгийн телевиз, FM-радиоогоор тухай бүр олон нийтэд мэдээлж ажиллаа.

Биелэлт -100%

3.6.Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх

Хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийг иргэдээс авахдаа хуулийн заалт, эрх зүйн үндэслэлийг сайтар танилцуулсны үндсэн дээр тусгай дансанд төвлөрүүлэх хэлбэрээр авч байна. Энэ асуудлын хүрээнд агентлаг албад, сумдын засаг дарга нарт үүрэг чиглэл өгсөний үр дүнд, сонин хэвлэл, хурал, зөвлөгөөнөөр сурталчлах, байгууллагын самбарт ил тодоор тодорхой тайлбартайгаар тавих зэргээр иргэдэд нээлттэй үйлчлэх тогтолцоо бүрдэж байна. Хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авахтай холбоотойгоор гомдол, санал одоогоор гараагүй байна.

Биелэлт -100%

3.7.Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх

Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамжийг авахдаа зөвхөн дансаар мөнгийг төвлөрүүлэх арга хэлбэрийг ашиглаж байна. Ингэхдээ төлбөр тооцооны дүнг цахим сүлжээнээс иргэд авах боломжийг бүрдүүлж байна.

Биелэлт -90%

Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

4.1.Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг гаргаж мэдээллийн самбарт байршуулж энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр улирал бүр сурталчлан ажилласны дүнд 2009 онд энэ чиглэлийн ажилд ямар нэг гомдол, зөрчил гараагүй болно.

Биелэлт -100 %

4.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/-т байршуулан, тогтмол шинэчилж байх

Түвшинширээ, Сүхбаатар сумын хүн эмнэлэгийн барилга, Халзан сумын сургуулийн барилгын дуусгал, Баруун-Урт сумын ус цэвэршүүлэх төхөөрөмж, сумдын ЗДТГазарт нийлүүлэх тоног төхөөрөмж, гэр төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийн урилгыг зууны мэдээ сонин болон цахим хуудаст байршуулан олон нийтэд мэдээлж ажилласны дүнд амжилттай зохион байгуулагдлаа.

Биелэлт -100 %

4.3.Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол/-ийг оролцуулсан байх

Үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын 2-оос дээш төлөөлөгчийг оруулахаар ТБОНӨХБАУХАТ хуулийн 47.5-т заасан үнэлгээний хорооны гишүүдийн олонхи нь худалдан

авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна гэсэн заалт зөрчигдөх тул тухайн салбарын 1 хүнийг оролцуулж ажиллалаа. Тухайлбал: Худаг усны тендерт усны инженер Б.Самбалхүндэв, Баруун-Урт сумын дулаан хангамжийн ТЭЗҮ боловсруулах тендерт дулааны инженер Б.Лантуу, Гэр төслийн тендерт “Талын зам” ХХК-ы дарга Ц.Хүрэлбор гэх мэт хүмүүсийг оролцуулсан.

Биелэлт -80 %

4.4.Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байх

Үнэлгээний хорооны 5-аас дээш тооны гишүүд тендерийн баримт бичгийг боловсруулдаг. Нээлттэй тендер шалгаруулалтын гүйцэтгэгчийг сонгосон үндэслэл үр дүнг цахим хуудаст байршуулан нийтэд танилцах боломжийг ханган ажиллаж байна.

Биелэлт -100 %

4.5.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх

Нээлттэй тендер шалгаруулалтанд оролцогчийн талаарх товч мэдээлэл болон тендер шалгаруулалтын үр дүнг цахим хуудаст байршуулж ажилласан. Тендерт шалгарч чадаагүй оролцогчдод шалгараагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийг тодорхой танилцуулж, тухай бүр албан бичгээр хариуг мэдэгдсэн болно.

Биелэлт -100 %

4.6.Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх

2009 оны10 сард нээлттэй хаалганы өдрөөр хөрөнгө оруулалтын тайланг олон нийтэд танилцуулж, худалдан авах ажиллагааны тайланг 1, 2-р маягтаар гаргаж байгууллагын мэдээллийн самбар, аймгийн вэб сайтад байршуулан иргэд олон нийтэд танилцуулж байна.

Биелэлт -100 %

4.7.Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх

2009 онд худалдан авах ажиллагааны талаар тендерт оролцогчдоос ямар нэгэн зөрчил дутагдал, өргөдөл, гомдол гараагүй болно.

Биелэлт -100 %

4.8.Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчдыг мэргэшүүлсэн байх

2009 оны 03 сард бүх сумдын төрийн сангийн төлөөлөгч нарт Худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, харьцуулалтын аргыг хэрэглэхдээ юуг анхаарах талаар 1 өдрийн сургалтыг СТСХэлтэсээс зохион байгуулж явуулсан.

Биелэлт -100 %

4.9.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх

2008 оны худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан дүгнэлтийг Хөгжлийн бодлогын хэлтэс болон бусад холбогдох албадад тарааж байгууллагын мэдээллийн самбарт 10 хоног байршуулж нийтэд сурталчиллаа.

Биелэлт -100 %

4.10.Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх

2009 онд худалдан авах ажиллагаатай холбоотой тендерт оролцогчдоос ямар нэгэн өргөдөл, гомдол ирээгүй болно.

Биелэлт -100 %

Нийт шалгуур үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийн хувь – 99.1

Оноо – 4.95

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР